



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/229

Номгон

「 Баянхонгор сумын хилийн цэсийн гадна  
олгогдсон нэгж талбарын зөрчлийг арилгах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.11, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2018 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан “Харьяалах нутаг дэвсгэрийн хилийн цэсийн гадна иргэн, хуулийн этгээдэд газар өмчлөх, эзэмших, ашиглах, эрх олгосон зөрчлийг арилгах ажлын заавар”-ын 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сумын хилийн цэсийн гадна олгогдсон Шаргалжуут орчмын нэгж талбарын зөрчлийг арилгаж, харьяалах нутаг дэвсгэрт шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажлыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Алтангэрэл - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Гишүүд: С.Батцэрэн - Баянхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Зөвшилцсөнөөр)

Г.Энхбаяр – Баянхонгор сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч

Б.Энхбаатар – Эрдэнэцогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Зөвшилцсөнөөр)

Д.Цэвэгдорж - Эрдэнэцогт сумын Засаг дарга

С.Должинсүрэн - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

А.Ганбат - Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн Засаг дарга

Х.Баасанжаргал - Баянхонгор сумын Газрын даамал

Б.Нармандах - Баянхонгор сумын Газрын даамал

Т.Пүрэвбаатар - Эрдэнэцогт сумын Жанжин 4 дүгээр багийн Засаг дарга

Д.Номинчимэг – Эрдэнэцогт сумын Газрын даамал


642310569

2.

Нарийн бичгийн дарга: А.Цэцэнбилэг - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга

2.Холбогдох хууль журмын дагуу хилийн цэсийн гадна олгогдсон нэгж талбаруудын зөрчлийг арилгаж, ажлын хэсгийн тайлан дүгнэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Засаг даргын дэргэдэх удирдлагын зөвлөлд танилцуулахыг ажиллахыг Ажлын хэсэг (Д.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН